



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 08

Баруун-Урт сум

Үндсэн хөрөнгө худалдах, шилжүүлэх,
актлаж данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/11 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, акталж данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 3 дугаар Хуралдаанас ТОГТООХ нь:

1.Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газар, Наран сумын Засаг даргын тамгын газар, Баруун Урт сумын Засаг даргын тамгын газар, Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газар, Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар, Онгон сумын Засаг даргын тамгын газар, Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Байгаль орчны газар, Асгат сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 524,980,720.00 (таван зуун хорин дөрвөн сая есөн зуун наян мянга долоон зуун хорь) төгрөгийн балансын үнэтэй, 524,980,720.00 (таван зуун хорин дөрвөн сая есөн зуун наян мянга долоон зуун хорь) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий нэгдүгээр хавсралтад заасан хөрөнгүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоосугай.

2.Сүхбаатар аймаг Засаг даргын тамгын газар, Сүхбаатар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Дарьганга сумын Засаг даргын тамгын газар, Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар, Халзан сумын Засаг даргын тамгын газар, Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газар, Аймгийн нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 383,155,000.00 (гурван зуун наян гурван сая нэг зуун тавин таван мянга) төгрөгийн балансын үнэтэй 382,946,666.59 (гурван зуун наян хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хоёрдугаар хавсралтад заасан хөрөнгүүдийг Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасны дагуу 10-аас дээш жилийн хугацаанд эзэмшсэн жолооч нарт тус тус худалдсугай.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит бус хорин хоёрдугаар хурлын 07, 2024 оны ээлжит бус хорин дөрөвдүгээр хурлын 02 тогтоолуудаар нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн боловч

худалдан борлуулагдаагүй “Хайлааст голомт” ОНӨААТҮГ, Наран сумын Ерөнхий боловсролын сургууль, “Сүхбаатар-Ойжуулалт сум дундын ойн анги” ОНӨААТҮГ, Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 61,500,000.00 (Жаран нэгэн сая таван зуу) төгрөгийн балансын үнэтэй 48,300,000.08 (Дөчин найман сая гурван зуу мянга найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий гуравдугаар хавсралтад заасан хөрөнгүүдийг дахин үнэ тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоосугай.

4.Дарьганга сумын Эрүүл мэндийн төв, Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 153,930,000.00 (Нэг зуун тавин гурван сая есөн зуун гучин мянга) төгрөгийн балансын үнэтэй, 21,103,333.28 (Хорин нэгэн сая нэг зуун гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий дөрөвдүгээр хавсралтад заасан хөрөнгүүдийг Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төв, Асгат сумын Эрүүл мэндийн төвүүдэд үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

5.“Бичиг их өргөө” ОНӨААТҮГ, аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Асгат сумын Эрүүл мэндийн төв, Асгат сумын Засаг даргын Тамгын газар, Онгон сумын Засаг даргын Тамгын газар, Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль, Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль, Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургууль, Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль, Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 200,185,596.62 (Хоёр зуун сая нэг зуун наян таван мянга таван зуун ерэн зургаан төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 90,506,478.38 (Ерэн сая таван зуун зургаан мянга дөрвөн зуун далан найман төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тавдугаар хавсралтад заасан хөрөнгүүдийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

6.Орон нутгийн өмчийн газар болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай.

6.1.Үндсэн хөрөнгийн худалдах, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

6.2.Шилжүүлэх хөрөнгийг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулах;

6.3.Акталж данснаас хасахаар шийдвэрлэсэн хөрөнгөөс цаашид ашиглаж болох материалыг орлого авч худалдан борлуулах;

6.4.Хөрөнгийн хөдөлгөөнийг хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д тусгах;

7.Тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

ДАРГА  Д.ХОСБАЯР